

Хүрээлэн буй орчны тогтвортой байдал

Байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах хууль ТОГТООМЖИЙГ САХИУЛАХ



Экологийн асуудал харуулсан
алба хаагчдын нэг өдөр



Монгол орон байгалийн баялгаар арвин бөгөөд нийт газар нутгийн 21 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг. Тус улсын байгаль хамгаалах хууль тогтоомж нь өргөн хүрээг хамардаг ч олон хүчин зүйлийн улмаас хэрэгжилт нь хангалтгүй байсаар байна. Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төсөл нь байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий алба хаагчдыг чадавхжуулах, олон улсын мэдлэг туршлагыг хуваалцах замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.

ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Монгол бол нүүдлийн соёл иргэншилтэй, ахуй амьдрал нь байгальд ээлтэй ч эдийн засаг нь байгалийн баялгаас ихээхэн хамааралтай орнуудын нэг юм. Аж үйлдвэр тогтвортой хөгжиж, эдийн засаг нь өргөжин тэлж, хүн амын өсөлт нэмэгдсэний улмаас 2000-аад оны эхэн үеэс байгальд (ус, хөрс, агаар) үзүүлэх сөрөг нөлөө ихээхэн нэмэгдсэн.

Түүнчлэн 2000-аад оноос хойших үул уурхайн салбар дахь өсөлт нь байгалийн баялгийг хувиараа хууль бусаар олборлох явдлыг нэмэгдүүлсэн.



Байгаль хамгаалах үхамсрыг иргэдэд төлөвшүүлэх, эрх зүйн үр дагаварыг тайлбарлан таниулах нь байгаль хамгаалах үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг юм

Монгол орны нийт газар нутгийн 21 орчим хувийг эзэлж буй тусгай хамгаалалттай бүсүүд нь дотроо хэд хэдэн ангилалд хуваагддаг (тухайлбал, байгалийн цогцолборт газар, шим мандлын нөөц газар, тусгай хамгаалалттай газар гэх мэт) тул эдгээр бүс нутгийн байгалийн нөөц, газар ашиглалтыг хамгаалахад чиглэсэн ялгамжтай зохицуулалт, дүрэм журам шаардлагатай юм.

Монгол Улсын Засгийн газар байгаль хамгаалах чиглэлд онцгой анхаарч, биологийн олон янз байдлыг хамгаалах тухай НҮБ-ын конвенци болон бусад зорилтуудыг хэрэгжүүлэхэд хичээл зүтгэл гаргасаар байна.

Сүүлийн жилүүдэд хийгдсэн байгаль орчны бодлогын шинэчлэл нь Монгол орны биологийн олон янз байдал болон байгалийн бусад нөөцийг хамгаалах нөхцөлийг эрс сайжруулсан ч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тал дээр учир дутагдалтай хэвээр байна.

Байгаль орчны тухай хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил, хууль сахиулах, хэрэгжүүлэх байгууллагын алба хаагчдын (экологийн цагдаа, байгаль хамгаалагч, экологийн шинжээч гэх мэт) хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, байгаль хамгаалах, байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах нь байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой байна.

ШИЙДЭЛ

Ханнс-Зайделийн сан нь Монгол Улсад эрх зүйн салбарт 30 орчим жил ажилласан туршлага дээрээ тулгуурлан үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөж, 2022 оноос байгаль орчны эрх зүйн салбарт төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хүрээнд экологийн цагдаа, байгаль хамгаалагч, экологийн шинжээч нарыг чадавхжуулах зорилгоор Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад түншлэгч байгууллагуудтай хамтран цуврал сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага судлах айлчлалуудыг зохион байгуулж байна.

Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор нөлөөллийн ажлыг хийхээс гадна олон улсын экспертүүдийг урьж, холбогдох сэдвээр дотоодын түнш байгууллагуудтай туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн зохион байгуулдаг.



Төр засаг, иргэний нийгэм, олон нийтийн дунд харилцан ойлголцлыг бий болгох нь чухал

Байгаль орчны эрх зүйн зохицуулалтын нөхцөлийг ойлгомжтой, уялдаатай болгож олон улсын жишигт нийцүүлэхийн тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар байгаль орчны хууль тогтоомжид учирч буй аливаа асуудал, бэрхшээлийг тодорхойлж, засч сайжруулах ажлыг зохион байгуулж байна.

МУИС-ийн Экологийн боловсролын төвтэй хамтран “Өсвөр үеийнхэн- Байгаль орчин ба Хууль” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн талаарх залуу үеийнхний мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Мөн байгаль орчны хууль сахиулах байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, байгаль орчны хууль тогтоомжийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, тэр дундаа байгаль орчныг хамгаалах, байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаль орчны эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.



Байгаль орчноо хамгаалах үхамсрыг төлөвшүүлэх үйл ажиллагааг бага наснаас нь эхлэх нь хамгийн үр дүнтэй.

ТҮНШЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ**



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



ЭКОЛОГИЙН ЦАГДАА



**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗАР**



**ЭКОЛОГИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВ**

Зургийг: Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төсөл

Холбоо барих:

@ info@hssmongolia.mn
www.mongolia.hss.de
www.facebook.com/HSFMongolia

Бусад Factsheet-р
эндээс:



Эрхлэн гаргасан:

Hanns-Seidel-Stiftung e.V. | Lazarettstr. 33, 80636 München
Tel. 089/1258-0 | E-Mail: info@hss.de | Online: www.hss.de
Vorsitzender: Markus Ferber, MdEP
Generalsekretär: Oliver Jörg
Leiterin des IIZ: Dr. Susanne Luther (V.i.S.d.P.)
Leiter PRÖ / Publikationen: Hubertus Klingsbögl
Kontakt: iiz@hss.de | Stand: 03/2022